



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/53/-НА-СТА-ТШЗ

<b>Цахим хуудас:</b> <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас: 99177546      Цахим хаяг: <a href="mailto:Vujinkhandj@audit.gov.mn">Vujinkhandj@audit.gov.mn</a>	
Аудитор	Г.Энхдэлгэр
Утас: 70484030      Цахим хаяг: <a href="mailto:Enkhdelgerg@audit.gov.mn">Enkhdelgerg@audit.gov.mn</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗООНОЗЫН  
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА  
С.БАТСАЙХАН ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 58  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020331



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>56,461,811.49</b>	<b>55,241,362.49</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	100,000.00	100,000.00
33100	Ажиллагчид тай холбогдсон авлага	100,000.00	100,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	56,361,811.49	55,141,362.49
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	6,880,179.00	13,404,180.00
35130	Эм боох материал	6,880,179.00	13,404,180.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,481,632.49	41,737,182.49
35410	Бичиг хэргийн материал	1,798,850.00	2,623,650.00
35420	Аж ахуйн материал	7,555,258.00	5,720,158.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,185,000.00	2,921,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,272,591.49	1,409,591.49
35450	Барилгын засварын материал	831,000.00	978,600.00
35470	Бусад хангамжийн материал	35,838,933.00	28,083,683.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>214,618,747.43</b>	<b>270,744,456.98</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	214,618,747.43	270,744,456.98
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	113,692,747.43	169,818,456.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	41,396,500.00	41,396,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,484,099.92)	(30,962,199.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,104,889.10	41,104,889.10
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,684,889.10)	(22,444,889.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,347,010.72	199,693,410.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,432,281.94)	(75,994,591.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,960,910.85	39,960,910.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,515,292.28)	(22,935,573.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,653,587.75	3,653,587.75
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,653,587.75)	(3,653,587.75)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	100,926,000.00	100,926,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	100,926,000.00	100,926,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>271,080,558.92</b>	<b>325,985,819.47</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>271,080,558.92</b>	<b>325,985,819.47</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	271,080,558.92	325,985,819.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	281,217,975.40	281,217,975.40
51101	Өмч: - төрийн	281,217,975.40	281,217,975.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(57,129,276.29)	(2,224,015.74)
51210	Өмнөх үеийн үр дүн	(57,129,276.29)	(57,129,276.29)
51220	Тайлант үеийн үр дүн	-	54,905,260.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,991,859.81	46,991,859.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>271,080,558.92</b>	<b>325,985,819.47</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	426,887,669.25	559,600,410.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,964,929.25	107,192,790.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,964,929.25	107,192,790.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,964,929.25	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	57,964,929.25	90,273,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		16,919,390.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,922,740.00	452,407,620.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,809,500.00	403,134,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	367,809,500.00	403,134,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,113,240.00	49,273,320.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	16,214,320.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	913,240.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	33,059,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	394,781,549.97	504,695,149.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,781,549.97	504,695,149.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,015,714.35	441,443,659.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,468,192.08	253,873,416.22
210101	Үндсэн цалин	171,171,913.08	166,992,207.22
210102	Нэмэгдэл	38,922,359.00	60,044,233.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,643,000.00	10,860,000.00
210104	Урамшуулал	23,730,920.00	15,976,976.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,014,004.92	35,918,849.08
210201	Тэтгэврийн даатгал	21,528,549.00	25,100,102.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,496,061.00	2,623,872.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,494,929.00	2,660,352.36
210204	Ажилгүйдлийн даатгал	499,292.00	545,750.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,995,173.92	4,988,771.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,487,006.86	15,086,429.31
210301	Гэрэл, цахилгаан	1,513,906.86	1,593,429.31
210302	Түлш, халаалт	13,923,000.00	13,299,000.00
210303	Цэвэр, бохир ус	51,000.00	194,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,302,820.12	40,224,516.00
210401	Бичиг хэрэг	5,618,350.00	4,519,050.00
210402	Тээвэр, шатахуун	10,920,449.60	13,160,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,333,056.52	1,067,695.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,588,030.00	7,798,710.00
210408	Бараа материал аялалсны зардал	3,842,934.00	13,679,061.00
2105	Нормативт зардал	16,456,184.50	35,160,698.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,456,184.50	35,160,698.00
2106	Эд хохшил, урсгал засварын зардал	6,199,500.00	3,790,500.00
210604	Урсгал засвар	6,199,500.00	3,790,500.00
2107	Томилголт, зочны зардал	4,763,000.00	6,282,000.00
210702	Дотоод албан томилолт	4,763,000.00	6,282,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,114,812.00	8,886,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,506,854.00	7,699,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	813,950.00	753,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,792.00	87,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	81,216.00	81,210.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	253,000.00	231,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,209,293.87	42,220,690.45
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,209,293.87	42,220,690.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,765,835.62	63,251,490.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	27,020,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	27,020,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,345,835.62	36,231,490.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,345,835.62	36,231,490.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	32,106,119.28	54,905,260.55
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	32,106,119.28	54,905,260.55

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	281,217,975.40	46,991,859.81	(57,129,276.29)	271,080,558.92
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	281,217,975.40	46,991,859.81	(57,129,276.29)	271,080,558.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	281,217,975.40	46,991,859.81	(57,129,276.29)	271,080,558.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	54,905,260.55	54,905,260.55
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	281,217,975.40	46,991,859.81	(2,224,015.74)	325,985,819.47

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>368,922,740.00</b>	<b>452,407,620.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>368,922,740.00</b>	<b>452,407,620.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>367,809,500.00</b>	<b>403,134,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	367,809,500.00	403,134,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,113,240.00</b>	<b>49,273,320.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	16,214,320.00
131103	ЗГНХ,ЗДН,Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	913,240.00	33,059,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>367,732,740.00</b>	<b>444,334,620.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>367,732,740.00</b>	<b>444,334,620.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>362,966,612.38</b>	<b>381,083,129.61</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>246,468,192.08</b>	<b>253,873,416.22</b>
210101	Үндсэн цалин	171,171,913.08	166,992,207.22
210102	Нэмэгдэл	38,922,359.00	60,044,233.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,643,000.00	10,860,000.00
210104	Урамшуулал	23,730,920.00	15,976,976.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,014,004.92</b>	<b>35,918,849.08</b>
210201	Тэтгэрийн даатгал	21,528,549.00	25,100,102.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,496,061.00	2,623,872.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,494,929.00	2,660,352.36
210204	Ажилгүйдлийн даатгал	499,292.00	545,750.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,995,173.92	4,988,771.25
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,758,906.86</b>	<b>15,733,429.31</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,513,906.86	1,593,429.31
210302	Түлш, халаалт	14,148,000.00	13,946,000.00
210303	Цэвэр, бохир ус	97,000.00	194,000.00
210304	Байрны түрээс	-	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,059,516.52</b>	<b>26,804,855.00</b>
210401	Бичиг хэрэг	5,476,850.00	4,557,050.00
210402	Тээвэр, шатахуун	9,440,000.00	12,650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,492,556.52	1,067,695.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,650,110.00	8,530,110.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,014,390.00</b>	<b>25,171,820.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,576,845.00	10,539,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,437,545.00	14,632,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,709,790.00</b>	<b>7,046,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,119,000.00	1,517,400.00
210604	Урсгал засвар	4,590,790.00	5,529,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>4,763,000.00</b>	<b>6,282,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	4,763,000.00	6,282,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,178,812.00</b>	<b>10,252,360.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,506,854.00	9,065,400.00
210803	Даялгалын үйлчилгээ	813,950.00	753,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,792.00	87,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	81,216.00	81,210.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	317,000.00	231,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,766,127.62</b>	<b>63,261,490.39</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>420,000.00</b>	<b>27,020,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	27,020,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,345,835.62</b>	<b>36,231,490.39</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,345,835.62	36,231,490.39
21336	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	292.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	292.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,190,000.00</b>	<b>8,073,000.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (6)</b>	<b>1,190,000.00</b>	<b>8,073,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,190,000.00</b>	<b>8,073,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,190,000.00</b>	<b>8,073,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,190,000.00	8,073,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,190,000.00)</b>	<b>(8,073,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	403,134,300.00	367,464,337.71
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	403,134,300.00	367,464,337.71
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	402,714,300.00	367,044,337.71
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	277,669,800.00	248,352,260.72
210101	Үндсэн цалин	173,942,500.00	161,471,051.72
210102	Нэмэгдэл	63,082,900.00	60,044,233.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,553,000.00	10,860,000.00
210104	Урамшуулал	26,091,400.00	15,976,976.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,262,100.00	34,982,512.68
210201	Тэтгэврийн даатгал	26,378,600.00	24,422,065.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,776,700.00	2,559,297.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,998,100.00	2,647,437.36
210204	Ажилгүйдлийн даатгал	555,300.00	494,090.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,553,400.00	4,859,621.45
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,764,600.00	15,733,429.31
210301	Гэрэл, цахилгаан	1,901,200.00	1,593,429.31
210302	Түлш, халаалт	13,286,400.00	13,946,000.00
210303	Цэвэр, бохир ус	577,000.00	194,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,962,900.00	23,956,855.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	4,557,050.00
210402	Тээвэр, шатахуун	17,333,700.00	12,650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,637,700.00	1,067,695.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	491,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	5,682,110.00
2105	<b>Нормативт зардал</b>	18,677,500.00	18,671,820.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,544,500.00	9,539,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,133,000.00	9,132,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,819,300.00	8,813,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,119,300.00	6,118,600.00
210604	Урсгал засвар	2,700,000.00	2,694,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	6,287,600.00	6,282,000.00
210702	Дотоод албан томилолт	6,287,600.00	6,282,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	11,270,500.00	10,252,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	9,084,600.00	9,065,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	941,000.00	753,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	87,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	100,900.00	81,210.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хур	813,000.00	231,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	420,000.00	420,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	420,000.00	420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	403,134,300.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	403,134,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	403,134,300.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		49,273,320.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		48,711,791.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		22,111,791.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,521,155.50
210101	Үндсэн цалин		5,521,155.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		936,336.40
210201	Тэтгэврийн даатгал		678,037.00
210202	Тэтгэмжийн даатгал		64,575.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		12,915.00
210204	Ажилгүйдлийн даатгал		51,659.60
210205	Эрүүл мэндийн даатгал		129,149.80
2104	Хангамж, бараа материалын зардал		2,848,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,848,000.00
2105	Нормативт зардал		6,500,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,000,000.00
210502	Хоол, хүнс		-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		5,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		6,306,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,471,800.00
210604	Урсгал засвар		2,834,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	26,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		26,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		26,600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		561,528.10
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		561,528.10
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	49,273,320.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		49,273,320.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		16,214,320.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		33,059,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зоонозын өвчин судлалын төв нь Говь-Алтай аймгийн хэмжээнд байгалийн голомтот, Зоонозын халдварт өвчний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах үүрэгтэй юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 394.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2020 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс материаллаг байдлыг тогтоосон нь 2021 оны үзүүлэлтээс их хэмжээний зөрүүтэй байна.

Мөн бид 2021 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилготой учраас 2021 оны үзүүлэлтийг суурь үзүүлэлтээр авч материаллаг байдлыг дахин тогтоох нь зөв гэж үзээд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 504.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20 хувиар буюу 54.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55.1 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр буурсан нь бараа материал акталсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 73.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүй 19.9 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 77.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, 13.7 сая төгрөгийн бараа материалыг акталж устгажээ. Оны эцэст 55.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 426.7 сая төгрөг болж сая 98.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 90.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд хөрөнгө актлаагүй ба тайлант оны эцэст 426.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд 0.1 сая төгрөгийн он дамнасан авлага бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 326.0 сая төгрөг болж 54.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 326.0 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 403.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 403.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 403.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 367.5 сая төгрөгийг зарцуулж 35.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 367.5 сая төгрөг буюу 91.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 29.3 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 5.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1.0 сая төгрөгөөр, тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ковидын үед ажилласан албан хаагчдын илүү цагийн мөнгө 6.5 сая төгрөг, 1 удаагийн тэтгэмж урамшуулал 26.6 сая төгрөг, тарвага нутагшуулах зориулалтаар 16.2 сая төгрөгийн санхүүжилт орж, илүү цаг, тэтгэмжийн зардалд 33.1 сая төгрөг, тарвага нутагшуулах ажилд 15.6 сая төгрөг зарцуулж, 0.6 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын санхүүгийн тайлан болон татварын цахим систем дэх татварын өглөг, авлагын тооцооллыг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 140 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 85.2 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

#### 3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 4.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 0.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар цалин тогтоолт, ажил хавсарсны нэмэгдлийг тооцож үзэх үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17.1 сая төгрөгийн алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад тайлант хугацаанд 12.6 сая төгрөгийн бараа материалын зарцуулалтыг зардлын зүйл ангиар залруулсан, 4.5 сая төгрөгийн төлбөрийн баримтыг цахим системд нөхөж шивүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Хавсран ажилласан нэмэгдлийг амралтын хугацаанд бүтэн бодож 0.1 сая төгрөг илүү олгосон нь Зоонозын өвчин судлалын төвийн даргын 2021 оны 1 сарын 4-ний өдрийн Б/01 тушаал "Ажиллагсдын цалин нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай" тушаалтай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Он дамнасан 0.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," заалттай нийцэхгүй бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Нийгмийн даатгалын тайланд цалинг илүү тайлагнаж, НДШ-д 1.7 сая төгрөг илүү төлсөн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх," заалттай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

Татварын тодорхойлолтоор 2.3 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нийгмийн даатгалын тайланд цалинг 6.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" заалттай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нийт зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 85.2 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

#### 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зоонозын өвчин судлалын төв	8	27.8	2	17.1	3	2.0	2	8.7	1	0

/сая төгрөгөөр/